


3 онооны даалгавар:

- 1) Дөрвөлжин шугамтай дэвтэрт U үсгийг зуржээ. Хэдэн ширхэг дөрвөлжин дүрс зурагт орсон бэ?




- A) 10 B) 8 C) 11 D) 13 E) 12

- 2) $0+1+2+3+4-3-2-1-0$ утгыг ол.

- A) 0 B) 2 C) 4 D) 10 E) 16

- 3) Эхний вагонд 10 хайрцаг ачжээ. Бусад бүх вагонд нь өмнөх вагон тус бүрээсээ хоёр дахин их хайрцаг ачаанууд ачсан бол тавдахь вагонд хэдэн хайрцаг ачаа ачсан бэ?



- A) 100 B) 120 C) 140 D) 160 E) 180

- 4) Зориггоо эхний кенгуруг хөх, дараагийн кенгуруг ногоон, тэгээд улаан, сүүлд нь шараар буджээ. Тэгснээ дахиад л хөх, ногоон, улаан, шар гэх мэт зуржээ. Долоодахь кенгуру ямар өнгөтэй вэ?

- A) хөх B) ногоон C) улаан D) хар E) шар

- 5) Багш нарын өрөөний 6 ширээ нь тус бүр 4 сандалтай, 4 ширээ нь тус бүр 2 сандалтай, 3 ширээ нь тус бүр 6 сандалтай. Тэгвэл тэнд нийт хэдэн сандал байна вэ?

- A) 25 B) 36 C) 40 D) 44 E) 50

- 6) Бундан дүрс нь бусад дүрснээсээ гурав дахин олон байх зургийг олоорой.



A)



B)



C)




D)



E)


- 7) Дөрвөлжин шугамтай цаасан дээр 7×4 хэмжээтэй тэгш өнцөгт зурав (Зураг). Түүний диагоналийг татвал хэдэн квадратыг дайрах вэ?

A) 8 B) 9 C) 10
D) 11 E) 12



- 8) Зурагт үзүүлсэн биет нь ижилхэн кубүүдээр хийгдсэн 189 грамм жинтэй. Нэг куб хэдэн грамм жинтэй вэ?

A) 29 B) 21 C) 25 D) 19 E) 17



4 онооны даалгавар:

- 9) Болд 3-аас эхлээд дараалсан натурал тоонуудыг бичиж 35 цифр болоход зогсов. Тэр хэдийн тоон дээр зогссон бэ?


A) 23 B) 22 C) 12 D) 28 E) 35

- 10) Бат орой 9:30-д унтаад маргааш өглөө 6:45-д сэржээ. Түүний дүү Ганаа Батаас 1 цаг 50 минутаар их унтсан бол Ганаа хэдэн цаг унтсан бэ?

A) 30 цаг 5 мин B) 11 цаг 35 мин C) 11 цаг 5 мин
D) 9 цаг 5 мин E) 8 цаг 35 мин

- 11) Нэгэн дүрсийн эхлэл ба төгсгөлийг дараах зурагт үзүүлжээ. Энэ нь хар ба цагаан зураасуудаас бүтэх ба нийт 17 зураас байна. Дүрсийн эхлэл ба төгсгөл нь хоёулаа хар бол энэ дүрсэд хичнээн цагаан зураас байгаа вэ?

A) 9 B) 16 C) 7 D) 8 E) 15



- 12) Кенгуру уртын харайлтын төрлөөр олимпод бэлджээ. Бэлтгэлийн үед түүний хамгийн урт харайлт нь 55 дм 50 мм байв. Гэтэл тэр олимпод өөрийнхөө амжилтаас 123 см-ээр урт харайжээ. Кенгуру олимпод хэр урт харайсан бэ?

A) 6 м 78 см B) 5 м 73 см C) 5 м 55 см
D) 11 м 28 см E) 7 м 23 см

- 13) Цэцгээ нэг тоо санаж түүнээс 214-г хасаад гарсан тоон дээр 2014 нэмэхэд хариу нь 20014 гарчээ. Анх ямар тоо санасан бэ?

A) 214 B) 17801 C) 18214 D) 21814 E) 2209


14) Хүслэн электрон цагныхаа дэлгэцэнд гарч байгаа цаг, минутыг заасан цифрүүдийг хооронд нь нэмэх дуртай. Жишээлбэл, 21:17 гэвэл $2 + 1 + 1 + 7 = 11$. Тэр хамгийн ихдээ хэдийн тоо (нийлбэр) гаргаж чадах вэ?

- A) 24 B) 36 C) 19 D) 25 E) 23

15) Мишээл найздаа “Хэрэв би одоо түүснээсээ хоёр дахин олон алим түүсэн бол одоогийнхоос 24-өөр олон алимтай байх байсан” гэв. Тэр хэдэн алим түүсэн бэ?

- A) 48 B) 24 C) 42 D) 12 E) 36

16) Шулуун шугам дээр A, B, C, D цэгүүд тэмдэглэв (Зураг). Хэрэв $AC = 10$ см, $BD = 15$ см, $AD = 22$ см бол B ба C цэгийн хоорондох зайг ол.



- A) 1 см B) 2 см C) 3 см D) 4 см E) 5 см

5 онооны даалгавар:

17) Ангийн 29 сурагчдын 12 нь эгчтэй, 18 нь ахтай. Энэ ангид зөвхөн Тамир, Баатар, Амар гурав л айлын том хүүхдүүд байв. Тэгвэл хэдэн сурагчид ах, эгч хоёулаа байгаа вэ?

- A) байхгүй B) 1 C) 3 D) 4 E) 6

18) Тогмид 11 цаастай байв. Тэр заримыг нь гурван хэсэг хуваав. Ингэхэд 29 ширхэг цаастай болсон бол хичнээн цаас хуваасан бэ?


- A) 3 B) 2 C) 8 D) 11 E) 9

19) Тэнүүн том, дунд, жижиг гурван төрлийн жигнэмэг худалдан авчээ. Том нь 4 зоос, дунд нь 2 зоос, жижиг нь 1 зоосны үнэтэй. Тэр тус бүрээс оролцуулж 10 жигнэмэг аваад 16 зоос төлжээ. Тэгвэл том жигнэмэг хэдийг худалдан авсан бэ?

- A) 5 B) 4 C) 3 D) 2 E) 1

20) Цэнгүүн ижил хэмжээтэй улаан ба хөх өнгийн куб ашиглан тэгш өнцөгт параллелопипед хийжээ (Зураг). Уг биетийн гадна талыг дандаа улаан, дотор талыг бүгдийг нь хөхөөр хийсэн бол Цэнгүүн хэдэн ширхэг хөх куб ашигласан бэ?



- A) 12 B) 24 C) 36 D) 40 E) 48




21) Санчир хэдэн сагсан бөмбөг худалдан авахаар болжээ. Хэрэв тэр 5 бөмбөг худалдан авбал 10 зоос илүү гарах байв. 7-г авбал 22 зоосны зээл хийх хэрэгтэй болно. Нэг бөмбөг ямар үнэтэй вэ?

- A) 11 B) 16 C) 22 D) 26 E) 32


22) Баяр гурван блок ашиглан $3 \times 2 \times 2$ хэмжээтэй тэгш өнцөгт параллелепипед хийжээ (Зураг). Блок бүр нь дөрвөн жижиг кубээс бүрдэх ба өөр өөр хэлбэртэй. Зурагт хоёр блок нь харагдаж байна. Харин цагаан блокны хоёр талс нь ил харагдана. Доорх зурагнуудаас аль нь цагаан блок вэ?




A)




B)



C)





D)




E)


23) Эвлүүлдэг тоглоом нь квадрат хэлбэртэй. Түүний хоёр хэсгийг будсан байна. Аль хоёр хэсгийг будсан байна вэ?




1



2



3



4

A) 1 ба 3 B) 2 ба 4 C) 2 ба 3 D) 1 ба 4 E) 3 ба 4

24) Тоглоомын дэлгүүрт нохой, баавгай, кенгуру худалдаж байв. 3 нохой, 2 баавгай нийлээд 4 кенгурутай тэнцүү үнэтэй. Мөн тийм хэмжээний мөнгөөр 1 нохой, 3 баавгай худалдан авч болно. Тэгвэл:

- A) Нохой баавгайнаас хоёр дахин үнэтэй
- B) Баавгай нохойноос хоёр дахин үнэтэй
- C) Баавгай нохой тэнцүү үнэтэй
- D) Нохой баавгайнаас гурав дахин үнэтэй
- E) Баавгай нохойноос гурав дахин үнэтэй